АЛАГ УУЛ ФИНАНС АУДИТ ХХК

АУДИТЫН ТАЙЛАН

Илланай ББСБ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлан

Улаанбаатар хот
2025 он

"АЛАГ УУЛ ФИНАНС АУДИТ"
ХХК
Монгол улс, Улаанбаатар хот, БЗД,
43-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэн
гудамж UB tower оффис, 3 давхар 303 тоот
Утас: 9911 5486, 7000 5486
И-мэйл: alaguulaudit@gmail.com

"ИЛЛАНАЙ ББСБ" ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

2025.02.05 № 25109
-ны № -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Бид "Илланай ББСБ" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, бусад тайлбар тодруулгуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх дүгнэлт

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд болох "Илланай ББСБ" ХХК-ийн 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг талаараа МУ-ын НББ-ийн тухай хуулийн дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан.
Бид Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу компаниас хараат бус байсан бөгөөд бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.
Бидний олж авсан аудитын нотолгоо бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, нөхцөл байдалдаа тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх, санхүүгийн тайлангуудыг аливаа заль мэх эсвэл алдаанаас шалтгаалсан материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэх, үнэн зөвөөр толилуулахтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх зэрэг багтана.

Засаглал хариуцсан этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангуудыг материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг мөрдөн ажиллахыг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудын сонголт нь санхүүгийн тайлангууд нь аливаа заль мэх, алдаанаас шалтгаалан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлүүдийн үнэлгээг хийхдээ аудитор санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэн толилуулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг харгалзан үзэх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгоор биш, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэгдэнэ. Аудитад мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой эсэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлууд багтана.

Бусад асуудал

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж. УНДРАХГЭРЭЛ

Илланай ББСБ ХХК
2024 оны 12 сарын 31
санхүүгийн тайлан

"ИЛЛАНАЙ ББСБ" ХХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр	Тодруулга	2024 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1	1,289,612,936.78	1,092,624,365.05
Зээл /цэврээр/	2	9,303,720,936.51	8,483,266,825.19
Бусад авлага	3	927,782,040.32	533,111,405.21
Эргэлтийн хөрөнгийн дүн		11,521,115,913.61	10,109,002,595.45
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	4	2,470,622.70	2,813,275.70
Биет бус хөрөнгө	5	5,550,142.03	5,550,142.03
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		8,020,764.73	8,363,417.73
Нийт хөрөнгийн дүн		**11,529,136,678.34**	**10,117,366,013.18**
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Бусад өр төлбөр	6	98,422,994.79	111,478,460.36
Богино хугацаат өр төлбөрийн дүн		98,422,994.79	111,478,460.36
Нийт өр төлбөрийн дүн		**98,422,994.79**	**111,478,460.36**
Эздийн өмч			
Хувь нийлүүлсэн хөрөнгө		3,400,000,000.00	3,400,000,000.00
Бусад өмч	7	23,615,231.70	23,615,231.70
Хуримтлагдсан ашиг, алдагдал		8,007,098,451.85	6,582,272,321.12
Эздийн өмчийн дүн		**11,430,713,683.55**	**10,005,887,552.82**
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		**11,529,136,678.34**	**10,117,366,013.18**

АЛТГУУЛ ФИНАНС АУДИТ ХХК

"ИЛЛАНАЙ ББСБ" ХХК

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

төгрөгөөр	тодруулга	2024 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон	2023 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон
Хүүгийн орлого	8	1,990,712,053.23	2,619,652,356.88
Хүүгийн зардал		-	-
Цэвэр хүүгийн орлого		**1,990,712,053.23**	**2,619,652,356.88**
Хүүгийн бус орлого	9	25,656,845.40	44,258,353.81
Хүүгийн бус зардал	10	153,135,421.16	112,667,954.10
Цэвэр хүүгийн бус орлого/зардлын дүн		**(127,478,575.76)**	**(68,409,600.29)**
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнох үйл ажиллагааны ашиг/алдагдал		1,863,233,477.47	2,551,242,756.59
Болзошгүй эрсдэлийн зардал	11	277,648,887.73	2,956,122.56
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	12	2,200,000.00	1,520,600.00
Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал		**1,583,384,589.74**	**2,546,766,034.03**
Ердийн бус орлого		-	-
Ердийн бус зардал		-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/		**1,583,384,589.74**	**2,546,766,034.03**
Орлогын татварын зардал	13	158,558,459.01	254,828,663.40
Цэвэр ашиг		**1,424,826,130.73**	**2,291,937,370.63**

АЛБАГҮЙ ФИНАНС АУДИТ ХХК

"ИЛЛАНАЙ ББСБ" ХХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	**3,400,000,000.0**	**23,615,231.70**	**6,582,272,321.12**	**10,005,887,552.82**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	3,400,000,000.0	23,615,231.70	6,582,272,321.12	10,005,887,552.82
Хуваарилсан ногдол ашиг				-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал			1,424,826,130.73	1,424,826,130.73
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Хувьцаат капиталын өсөлт	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	**3,400,000,000.0**	**23,615,231.70**	**8,007,098,451.85**	**11,430,713,683.55**

АЛАГ УЗЛ ФИНАНС АУДИТ ХХК

"ИЛЛАНАЙ ББСБ" ХХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр	2024 он	2023 он
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**7,728,164,908.77**	**24,458,839,690.75**
Зээлийн хүүгийн орлого	1,585,746,108.97	2,622,842,292.16
Харилцах дансны хүүгийн орлого	9,499,065.77	3,333,378.96
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	22,674,500.00	28,316,527.53
Бусад үйлчилгээний орлого	6,110,245,234.03	21,804,347,492.10
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**7,531,176,337.04**	**20,914,182,619.15**
Үндсэн ба нэмэгдэл цалин	66,836,090.00	47,730,425.00
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	4,940,952.00	5,083,010.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	20,120,000.00	13,495,000.00
Албан томилолт, сургалтын зардал	105,000.00	715,000.00
Шатахуун, холбоо, интернэт, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	3,283,023.89	3,001,237.00
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	664,190.00	1,038,990.00
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	42,030.00	
Татвар, даатгалд төлсөн мөнгө	176,720,009.96	743,200,244.79
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	8,387,000.00	13,283,700.00
Ногдол ашгаар олгосон мөнгө	-	4,050,001,800.00
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	7,204,988,552.21	16,011,990,448.69
Зохицуулалт, үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,240,000.00	-
Бусад үйлчилгэнд төлсөн мөнгө	41,849,488.98	24,642,763.67
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**196,988,571.73**	**3,544,657,071.60**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	-	**500,000,000.00**
Бусад		500,000,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	**3,011,520,600.00**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал		1,520,600.00
Бусад		3,010,000,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	**(2,511,520,600.00)**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	196,988,571.73	1,033,136,471.60
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,092,624,365.05	59,487,893.45
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,289,612,936.78	1,092,624,365.05

